



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
иргэдийг томилон оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Худалдан авах ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах, иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах замаар худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх АЗ гэрчилгээний сургалтад хамрагдаж батламж авсан хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилон оролцуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оролцуулж, Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100025

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын
22-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт



Дүүргийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
томилогдон ажиллах иргэдийн нэрсийн жагсаалт

Д/д	Нэрс	Гэрийн хаяг	Мэргэжил	Утасны дугаар
1	Д.Дашдамба	1 дүгээр хороо 38-4 тоот	Эрх зүйч	99091540
2	Д.Эрдэнэтуяа	2 дугаар хороо 2 дугаар мянгатын 23-38 тоот	Эрх зүйч	96050317
3	Б.Болормаа	2 дугаар хороо 40 мянгатын 22-40 тоот	Инженер	88081769
4	П.Уянга	4 дүгээр хороо Бага тойруу 3а-5 тоот	Эрх зүйч	99173212
5	Б.Эрдэнэцог	4 дүгээр хороо Бага тойруу 21-2 тоот	Инженер-эдийн засагч	99186753
6	Э.Өлзийжаргал	5 дугаар хороо 6 дугаар хороолол 18-29 тоот	Хүний нөөцийн менежер	88838881
7	Ч.Жадамба	6 дугаар хороо 52-10 тоот	Хуульч, эрх зүйч	91156170, 99042508
8	С.Октябрьтуяа	6 дугаар хорооны 41-1 тоот	Эдийн засагч	94665288
9	Л.Ган-Өлзий	8 дугаар хороо Зүүн тасан 7-114 тоот	Нягтлан бодогч	99186181
10	Э.Бадамгарав	10 дугаар хороо Дэнжийн 30-380 тоот	Эдийн засагч	99246030
11	Л.Лувсанцэрэн	9 дүгээр хороо Дэнжийн 1-126	Эдийн засагч	99905523
12	М.Мөнхтөр	13 дугаар хороо Сургуулийн 37-741А тоот	Эдийн засагч инженер	99022151
13	Ё.Рэнцэнноров	13 дугаар хороо Сургуулийн 37-741а тоот	Эдийн засагч инженер	99146602
14	Д.Уранчимэг	13 дугаар хороо Сурагчийн 5-67 тоот	Нягтлан бодогч	96378090
15	Н.Наранчимэг	13 дугаар хороо, 39-791 тоот	Эдийн засагч, төсөвчин	80882627
16	У.Вандан	15 дугаар хороо, Хандгайт 1-8 тоот	Эдийн засагч, химич	88090056 99289690
17	Д.Батболд	15 дугаар хороо Жаргалантын 31-5166 тоот	Малын эмч	91187872, 89995046
18	Б.Ундрам	17 дугаар хороо Сурагчийн 49-16 тоот	Бизнесийн удирдлага	88889778
19	С.Энхбаяр	19 дүгээр хороо Дээд салхит 26-403а тоот	Нягтлан бодогч	91116659



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 15 дугаар тогтоолын хавсралтын 1.9 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах замаар нутгийн өөрөө удирдах байгууллагыг анхан шатны нэгжид төлөвшүүлэх, хурлын байгууллагын байнгын тогтвортой үйл ажиллагааг хангах, чадавхыг нь бэхжүүлэх зорилгоор тэдгээрт дэмжлэг үзүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хороодын Иргэдийн Нийтийн Хуралд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жил бүрийн төсөвт тусган, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү журмыг 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100033

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын
22-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



Чингэлтэй дүүргийн хороодын Иргэдийн
Нийтийн Хуралд дэмжлэг үзүүлэх журам

1. Энэхүү журмын зорилго нь хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сайн туршлагыг нь түгээн дэлгэрүүлж, үйл ажиллагааг нь сурталчилах, шагнаж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь хороодын Иргэдийн Нийтийн Хурлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, дараах чиглэлээр үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлж хамтран ажиллана.
 - 2.1. Цаг үеийн болон шаардлагатай асуудлаар Мэдээллийн цагт тогтмол хамруулах;
 - 2.2. Сургалтын эрэлт хэрэгцээ, ажлын шаардлагыг харгалзан зорилтод болон захиалгат сургалтад хамруулах;
 - 2.3. Албан хэрэгцээнд шаардлагатай хууль тогтоомж, ном, сэтгүүл, гарын авлага материалаар хангах;
 - 2.4. Хурал, цуглаан, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардлагатай үзүүлэх болон зурагт хуудас, баримт материал, техник тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх;
 - 2.5. Ажлын байрны тавилга, тоног төхөөрөмж, албан хэрэгцээнд ашиглагдах шаардлагатай бичиг хэрэг хангамжаар хангах;
 - 2.6. Гадаад, дотоодын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, харилцан туршлага солилцох, сайн туршлагыг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
 - 2.7. Ажлын сайн туршлагыг нь түгээн дэлгэрүүлж, түүнийг хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчилах;
3. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт дараах буцалтгүй мөнгөн тусламж олгоно.

3.1. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нас барсан бол түүний ар гэрт 1000000 (нэг сая) төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж;

3.2. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын даргын эхнэр /нөхөр/, төрсөн болон хадам эцэг /эх/, төрсөн ах, эгч, дүү, төрсөн хүүхэд нас барвал 300000 (гурван зуун мянга) төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж;

3.3. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга хүндээр өвчилсөн болон Монгол Улсад эмчилгээ оношлогоо хийгдэх боломжгүй, гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай тухай эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн эмчилгээний зардалд зориулж 3000000 (гурван сая) хүртэл төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлж болно.

4. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг анхан шатны нэгжид төлөвшүүлэхэд идэвх зүтгэл гарган ажилласан Иргэдийн Нийтийн Хурлыг жилд 1 удаа 500000 (таван зуун мянга) хүртэлх төгрөгөөр шагнаж урамшуулна.

5. Хороодын Иргэдийн Нийтийн Хурал нь жилийн үйл ажиллагааныхаа тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, Хурлын Ажлын албанд тухай бүрт хүргүүлж ажиллана.

6. Хороодын Иргэдийн Нийтийн Хуралд дэмжлэг, туслалцаа, буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэхэд шаардагдах зардлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, нийгмийн хэв журмыг хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх, иргэдийн оролцоонд суурилсан хяналттай, эрүүл, аюулгүй, амар тайван орчин бий болгох зорилгоор дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журмыг нэгдүгээр, Хороодын нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн ажиллах журмыг хоёрдугаар, Хороодод ажиллах хэв журмын урамшилтай эргүүлийн ажиллах журмыг гуравдугаар, Хороодын гудамж, байранд нийтийн эргүүл ажиллуулах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 12, 13, 25 дугаар тогтоол, 2016 оны 02 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү журмыг 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1159100040

D:12017 Tagtool



Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн
ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/-ийн ажиллах журмын зорилго нь зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр, бүрэлдэхүүн түүний эрх үүрэг, удирдлага зохион байгуулалт, ажлын төлөвлөгөө, тайлан, санхүүжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль хяналтын болон төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгож, уг журмаар тодорхойлсон чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

1.3. Энэхүү журмын хэрэгжилтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга зохион байгуулж, Зөвлөлийн дарга хяналт тавина.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, удирдлага,
зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь 15 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүн, ажиллах журмыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт зааснаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.

2.2. Зөвлөлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга удирдах бөгөөд дэд дарга нь дүүргийн Засаг дарга, гишүүд нь тухайн нутаг дэвсгэрийн хууль хяналтын болон төр захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнууд байна.

2.3. Зөвлөл нь Нарийн бичгийн даргатай байх бөгөөд тухайн асуудлыг хариуцсан Хурлын Ажлын албаны ажилтан байна.

2.4. Нарийн бичгийн дарга нь зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, зөвлөлийн дарга, гишүүдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллана.

2.5. Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.6. Зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь зөвлөлийн даргын гарын үсэг бүхий үнэмлэхтэй байна.

2.7. Зөвлөлийн гишүүдийн хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүнг харгалзан тэдэнд урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын хэмжээг зөвлөл өөрөө тогтооно.

2.8. Зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагаанд тухайн нутаг дэвсгэрийн төр захиргаа, хууль хяналтын байгууллагын холбогдох албан тушаалтнууд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

2.9. Зөвлөл нь үйл ажиллагаагаа дээд шатны салбар зөвлөлд улирал тутам тайлагнана.

2.10. Зөвлөл нь хороодод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий баг /цаашид “Урьдчилан сэргийлэх баг” гэх/ байгуулах бөгөөд багийн бүрэлдэхүүнийг тухайн хорооны Засаг даргын саналыг үндэслэн байгуулна.

Гурав. Зөвлөлийн хуралдаан, үйл ажиллагааны хэлбэр

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан байна.

3.2. Зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдан гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүн, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, цаг үеийн болон бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.3. Зөвлөлийн хуралдаанд гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцно.

3.4. Зөвлөлийн хуралдаанаас тогтоол гарах бөгөөд зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар зөвлөмж, уриалга гаргаж болно.

3.6. Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг тухайн нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Зөвлөлийн гүйцэтгэх чиг үүрэг

4.1. Зөвлөл нь хууль тогтоомжоор хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах нийтлэг чиг үүргийн хүрээнд ажиллана.

- 4.1.1. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчилах ажлыг зохион байгуулах;
- 4.1.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.1.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаар иргэд, байгууллагаас гаргасан санал, санаачлагыг судлан дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;
- 4.1.4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр зохион байгуулсан ажилд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах;
- 4.1.5. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
- 4.1.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр байгуулагдсан Урьдчилан сэргийлэх баг, Хэв журмын урамшилтай эргүүл, Нийтийн эргүүлүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар чиглэл өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, сургалтад хамруулах, шаардлагатай гарын авлага, материалаар хангах;
- 4.1.7. Байгууллага, иргэдийн үүсгэл санаачлагаар хийгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах;
- 4.1.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдэж буй ажлын хүрээнд байгууллага хоорондын болон иргэдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллах;

Тав. Зөвлөлийн бүрэн эрх

5.1. Зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- 5.1.1. Дүүргийн хэмжээнд нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор зохион байгуулсан ажлын тайлан мэдээг холбогдох байгууллагаас гаргуулан авах;
- 5.1.2. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах, сахилга дэг журмыг бэхжүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж, зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулах энэ чиглэлээр тухайн нутаг дэвсгэрийн нутгийн захиргаа, хууль хяналт, мэргэжлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж заавар, чиглэл өгөх;

5.1.3. Дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангахад чиглэсэн хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, асуудал боловсруулахад холбогдох мэргэжлийн байгууллагын ажилтнуудыг тухайн байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах;

5.1.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах асуудлаар зайлшгүй шаардлагатай мэдээ, тооцоо, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

5.1.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллага хамт олныг шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох;

5.1.6. Зөвлөлийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

Зургаа. Зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан

6.1. Зөвлөл нь ажлаа төлөвлөхдөө байгууллага, иргэдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлбэл зохих ажлын саналыг авч тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусган боловсруулж жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

6.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал, хагас, бүтэн жилээр гарган дээд шатны зөвлөлд хүргүүлнэ.

Долоо. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

7.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан ажилд зарцуулна.

7.2. Зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, журам, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсэгт заасны дагуу дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс санхүүжүүлнэ.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 02 дугаар сарын 22-ны
өдрийн 11 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



Хороодын нутаг дэвсгэрт Гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн
ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Чингэлтэй дүүргийн хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий баг /цаашид "Урьдчилан сэргийлэх баг" гэх/-ийн үйл ажиллагааны чиглэл, ажлын зохион байгуулалт, үнэлж дүгнэх, шагнаж урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Урьдчилан сэргийлэх баг нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэр болон энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Хорооны Урьдчилан сэргийлэх баг нь 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ахлагч, гишүүдээс бүрдэнэ. Урьдчилан сэргийлэх баг, бүрэлдэхүүнийг тухайн хорооны Засаг даргын саналыг үндэслэн дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл байгуулна.

2.2. Урьдчилан сэргийлэх багийн ахлагч нь дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргатай жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан гэрээ байгуулж ажиллана.

2.3. Урьдчилан сэргийлэх баг нь:

2.3.1. Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр хууль хяналтын байгууллага, иргэдтэй хамтран ажиллах замаар иргэдийн амар тайван аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.3.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийг татан оролцуулах ажлыг зохион байгуулна.

2.3.3. Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах талаар хийж, хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүн, иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагын бүлгийн хийсэн ажлын явц, үр дүнг хэлэлцэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажилд үнэлэлт дүгнэлт өгч, саналаа дүүргийн салбар зөвлөлд хүргүүлж ажиллана.

2.4. Урьдчилан сэргийлэх баг нь хэлэлцсэн асуудал бүрийг тэмдэглэлээр баримтжуулах бөгөөд тэмдэглэлд багийн ахлагч гарын үсэг зурж баталгаажуулна.

2.5. Урьдчилан сэргийлэх баг нь зохион байгуулсан үйл ажиллагааныхаа тайлан мэдээг сар бүрийн 10-ны дотор нэгтгэн дүгнэж, дүүргийн салбар зөвлөлд хүргүүлнэ.

2.6. Урьдчилан сэргийлэх баг нь хагас, бүтэн жилээр ажлаа төлөвлөн биелэлт, үр дүнг тооцон ажиллана.

2.7. Урьдчилан сэргийлэх баг нь дүүргийн салбар зөвлөлийн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажил, хүрсэн үр дүнг зөвлөлд тайлагнана.

Гурав. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

3.1. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хорооны хэмжээнд удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийг сурталчилах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад хандсан соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж явц, үр дүнг тооцох замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд оршино.

3.2. Хорооны Урьдчилан сэргийлэх баг нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1 Нутгийн захиргааны байгууллага болон шүүх, прокурор, хууль хяналт, мэргэжлийн байгууллагуудтай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хорооны хэмжээнд удирдан зохион байгуулах;

3.2.2 Иргэдийнхээ амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх

чиглэлээр иргэд, олон нийтээс гаргасан санал, санаачлагыг дэмжиж, хамтран ажиллах;

3.2.3. Харьяа нутаг дэвсгэртээ олон нийт, иргэдийн оролцоотой эргүүл зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллах;

3.2.4. Хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.5. Хороодод ажиллаж буй Иргэдийн бүлэг, үүсгэл санаачлагыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, дээд шатны байгууллагад уламжлах;

3.2.6. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын явц, үр дүнтэй танилцах, заавар, зөвлөгөө өгөх, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах;

3.2.7. Шаардлагатай мэдээ, судалгааг гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх;

3.2.8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах чиглэлээр хорооны хэмжээнд шинэ санал, санаачлага гарган ажил зохион байгуулах;

3.2.9. Гудамж, байр бүрээс сайн дурын үндсэн дээр тухайн гудамж, байрны байнгын оршин суугч иргэнийг нийтийн эргүүлээр ажиллуулахаар сонгон шийдвэр гарган, бүртгэлжүүлэн ажиллуулах;

3.2.10. Хэв журмын урамшилт эргүүл, нийтийн эргүүлүүдээс ирсэн дуудлага мэдээллийг “Зөрчлийн бүртгэл”-д бүртгэж, хорооны хэсгийн байцаагчид мэдээлж, шийдвэрлүүлэх;

Дөрөв. Урьдчилан сэргийлэх багийн эрх

4.1. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн ахлагч нь багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хуралдаан даргалах, гишүүддээ ажил үүргийг хуваарилан хариуцуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, ажлын үр дүнг тооцон ажиллах;

4.2. Нийгмийн дэг журам, хууль тогтоомжийг удаа дараа зөрчиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагад арга хэмжээ авахуулах, шийтгэл ногдуулах саналыг төр захиргаа, хууль хяналт, мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;

4.3. Иргэдийн амар тайван амьдрах нөхцөл, бололцоог бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорооны хэмжээнд тулгамдсан асуудлыг Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж тогтоол гаргуулах;

4.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг шагнаж урамшуулах, төр засгийн шагналд уламжлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

Тав. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн ажлыг дүгнэх, түүнд урамшуулал олгох

5.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг харгалзан хорооны Засаг даргын үндсэн цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг Урьдчилан сэргийлэх багт олгох ба дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

5.2. Багт олгох урамшууллын 30 хувийг багийн ахлагчид, 70 хувийг багийн гишүүдэд ажил дүгнэсэн үзүүлэлтийн дагуу хуваарилан олгоно.

5.3. Урамшууллыг олгохдоо хорооны Урьдчилан сэргийлэх багийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайланг үндэслэн батлагдсан үзүүлэлтийн дагуу дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн шийдвэрээр олгох бөгөөд Урьдчилан сэргийлэх багийн гишүүдийн ажлыг багийн ахлагч, багийн ахлагчийн ажлыг дүүргийн салбар зөвлөл тус тус дүгнэнэ.

5.4. Тайлан хэлэлцэх хурлаа хийгээгүй, тайлан мэдээг хугацаа хожимдуулсан, хангалтгүй ажилласан Урьдчилан сэргийлэх багийн урамшууллыг олгохгүй.

5.5. Урьдчилан сэргийлэх багийн ахлагч, гишүүдийн ажлыг дүгнэх үзүүлэлт

№	Ажил дүгнэх үзүүлэлт	Урьдчилан сэргийлэх багийн ахлагч	Гишүүн	Гишүүн	Гишүүн	Гишүүн	0-20 оноо	Тайлбар
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, хүрсэн үр дүн	✓	✓	✓	✓	✓		
2	Урьдчилан сэргийлэх багийн үйл ажиллагаа, хүрсэн үр дүн	✓						

3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулсан байдал	✓	✓	✓	✓	✓		
4	Шинэ санаа, санаачилга болон зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан байдал	✓	✓	✓	✓	✓		
5	Өгсөн үүрэг даалгаварын биелэлт, тайлан мэдээ ирүүлсэн хугацаа	✓	✓	✓	✓	✓		
	Нийт оноо							

5.6. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга дээрх ажил дүгнэсэн үзүүлэлтийг нэгтгэн дүүргийн салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан урамшууллын хэмжээг шийдвэрлүүлнэ.

5.7. Хорооны Урьдчилан сэргийлэх багийн ахлагч болон гишүүдийн хийсэн ажлын үр дүнг харгалзан урамшууллыг үзүүлэлтийн дагуу 50-100 хувийн хооронд оноогоор дүгнэж олгоно.

91 - 100 оноо - 100%

81 - 90 оноо - 90%

61 - 80 оноо - 80%

50 - 60 оноо - 50% -ийн урамшуулал тус тус олгогдоно.

49%-иас доош оноогоор үнэлэгдсэн болон хугацаа хожимдуулсан тохиолдолд урамшуулал олгохгүй.



Хороодод ажиллах Хэв журмын урамшилтай
эргүүлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий хэв журмын урамшилтай эргүүл /цаашид “Урамшилт эргүүл” гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Урамшилт эргүүл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон ажиллана.

1.3. Урамшилт эргүүл нь хорооны Урьдчилан сэргийлэх багийн ахлагчийн шууд удирдлага дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хорооны хэсгийн байцаагч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.4. Урамшилт эргүүл нь тухайн хорооны нутаг дэвсгэрт байнга оршин суугч, 18 нас хүрсэн, дээд боловсролтой, эрүүл мэндийн хувьд үүрэг гүйцэтгэх чадвартай Монгол Улсын иргэн байна.

1.5. Урамшилт эргүүлээр ажиллах иргэнийг тухайн хорооны Засаг даргын саналыг үндэслэн дүүргийн Засаг даргын захирамжаар томилж, чөлөөлөх бөгөөд хорооны Засаг дарга, дүүргийн Засаг даргын Тамгын газартай гурвалсан гэрээ байгуулж ажиллана.

Хоёр. Урамшилт эргүүлийн үйл ажиллагааны зорилго,
үндсэн чиг үүрэг

2.1. Урамшилт эргүүл нь тухайн хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангуулах, энэ чиглэлээр төр, захиргаа, хууль хяналтын байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажилд дэмжлэг тусалцаа үзүүлэх, хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн талаар холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх замаар иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.2. Урамшилт эргүүл нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас гаргасан хууль тогтоомж, дүрэм журмыг иргэд олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдийн дунд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Гэмт хэрэг болон нийгмийн хэв журмын зөрчлийг цагдаагийн байгууллага болон холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх;

2.2.3. Тухайн хорооны гэмт хэргийн шалтгаан нөхцөл, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж, талбай, аж ахуйн нэгж байгууллагуудад хэсэгчилсэн байдлаар ажиглалт хийж, эргүүлийн үүргийг тогтмол гүйцэтгэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах;

2.3. Журмаар тогтоосон чиг үүргээ гүйцэтгэхдээ хорооны Урьдчилан сэргийлэх баг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, холбогдох байгууллагуудаас дэмжлэг тусалцаа авах эрхтэй;

Гурав. Урамшилт эргүүлийн үйл ажиллагааны баталгаа,
урамшуулал, хориглох зүйл, хариуцлага

3.1. Урамшилт эргүүлд журмаар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө сар бүр мөнгөн урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээ, ажиллах хүний тоог дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

3.2. Урамшилт эргүүл нь ажлаа батлагдсан ажил дүгнэх үзүүлэлтийн дагуу хорооны Урьдчилан сэргийлэх багаар дүгнүүлэн сар бүрийн 10-ны дотор ажил дүгнэсэн үзүүлэлтийг илтгэх хуудсын хамт дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ирүүлнэ.

3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эргүүлийн ажил дүгнэсэн үзүүлэлтийг нэгтгэн илтгэх хуудсын хамт дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдаанд танилцуулан урамшууллын шийдвэрийг гаргуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

3.4. Урамшилт эргүүлийн мөнгөн урамшууллыг Засаг даргын тамгын газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зардлаас санхүүжүүлнэ.

3.5. Урамшилт эргүүл нь үнэмлэх, таних тэмдэг бүхий хувцас, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай туслах хэрэгсэлтэй байна.

3.6. Урамшилт эргүүл нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийгмийн баталгааг эдэлнэ.

3.7. Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эрүүл мэнд, амь насанд хохирол учирсан тохиолдолд шуурхай шийдвэрлэж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс тусламж дэмжлэг үзүүлнэ.

3.8. Урамшилт эргүүл нь хүн саатуулах, тээврийн хэрэгслийг зогсоох, иргэний биед болон тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг хурааж авах, хууль хяналтын байгууллагын нэр барих, цагдаагийн албан хаагчийн дүрэмт хувцас өмсөх, тусгай хэрэгслэл /гав, бороохой зэрэг/ ашиглах, албан үүргийн дагуу олж авсан хувь хүн, албан байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас бусад этгээдэд өгөхийг хориглоно.

